| 22. | Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. | Батлагдаж хэрэгжсэн төслийн тоо, санхүүжил-тийн хэмжээ | Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын санхүүжилтийн 5 сая ам.долларын төслийг батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн. | Шинээр хэрэгжүүлэх төсөл батлуулсан байна. | - НҮБХС-нд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн саналыг боловсруулан хүргүүлж, "КОВИД-19 халдвартай тэмцэх эм, эмчилгээний тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг дэмжих ACT-A SFF" механизмын нэмэлт санхүүжилтээр **706,3 мян.ам.долларын** холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэх төслийг батлуулсан.<br>- ХБНГУ-ын ЗГ-аас Монгол Улсад олгосон хөнгөлөлттэй зээлийн 34 сая евро/29 сая ам.долларын өрийг Өр шилжүүлэх D2H санаачлагын хүрээнд эрүүл мэндийн салбарт зарцуулах болсны дагуу Глобаль санд элэгний гепатит Д вирусийн халдвартай иргэдэд "Гурвалсан халдварыг тэглэх" стратегийн хүрээнд **2,3** сая ам.долларт АНУ-ын "Гилеад Сайэнсис Инк" компанийн Булевиртид эмийн эмчилгээг нэвтрүүлэх санал аургүүлсэн. Уг төслийг хянах үйл ажиллагаа Глбаль санд хийгдэж байна.<br>- Kerry Mining (Mongolia) Limited-ийн **1,0** сая ам.долларын санхүүжилт бүхий "Хавдрын эм худалдан авах" төслийг батлуулаад байна. | I.02-XII.31 | 100.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай 2024-2028 онд хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегийг боловсруулж батлуулна. | Батлагдсан стратеги | - | Хамтын ажиллагааны стратегийг боловсруулж батлуулсан байна. | Монгол Улсын Засгийн газар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай 2024-2028 онд хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегийг эцэслэн батлахтай холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр холбогдох эрүүл мэндийн байгууллагуудыг оролцуулан хэлэлцүүлэг хийж, баримт бичгийг эцэслэсэн.<br>Эрүүл мэндийн сайд С.Чинзориг ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал Др.Саиа Ма'у Пиукала нар хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан. | I.02-XII.31 | 100.0 |
| 24. | Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран Монгол Улсын хорт хавдарын хяналтын чадавхид цогц үнэлгээ хийлгэнэ. | Үнэлгээний тайлан | НҮБ-ын Олон улсын атомын энергийн агентлагтай Улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх "Монгол Улсад хорт хавдрын менежментийг сайжруулах" техникийн туслалцааны төслийн саналыг боловсруулж, ОУАЭА батлан | Үнэлгээ хийгдэж, дүгнэлт, зөвлөмж танилцуулагд-сан байна. | - Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хамтарсан баг 2024 оны 1-4 дүгээр саруудад үндэсний экспертүүдтэй цахимаар баримт бичгийн үнэлгээ хийх болон Монгол Улсад 2024 оны 5 дугаар сарын 5-10-ны өдрүүдэд биетээр хийсэн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан. Олон улсын үнэлгээний баг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж, хавдрын тусламж, үйлчилгээний үйл ажиллагаатай биечлэн танилцаж, үнэлгээний багийн зүгээс урьдчилсан үнэлгээ, зөвлөмж, дүгнэлтийг Эрүүл мэндийн яамны удирдлагын түвшинд | I.02-XII.31 | 100.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлж эхэлсэн. | | мөн үндэсний экспертүүдэд танилцуулсан.<br>- Үнэлгээний эцсийн дэлгэрэнгүй тайлан, зөвлөмж, дүгнэлтийг Олон улсын атомын энергийн агентлагаас 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч, улмаар Эрүүл мэндийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 1а/3569 дүгээр албан бичгээр төрийн холбогдох 8 байгууллагад хүргүүлж, тайланд тусгах саналыг нэгбүрчлэн авсан. Байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг судлан, ангилж нэгтгэн ОУАЭА-т 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн. | | |
| 25. | Гадаад хамтын ажиллагааны 2023 оны үйл ажиллагааны бичмэл тайланг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | Хугацаанд нь хүргүүлсэн тайлан | Жил бүр ГХЯ-д тайлан хүргүүлдэг. | Эрүүл мэндийн салбарын гадаад хамтын ажиллагааны тайлан ГХЯ-нд хүргэгдсэн байна. | Эрүүл мэндийн яамны гадаад хамтын ажиллагааны 2023 оны үйл ажиллагааны бичмэл тайланг 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр 2/26 дугаар албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. | I.02-XII.31 | 100.0 |
| 26. | Бүгд Найрамдах Солонгос Улсын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлагтай хамтран ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | Хамтын ажиллагааны чиглэл | - | Хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгож, хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойлсон байна. | Монгол Улсын Эрүүл мэндийн яам, БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг хооронд Нийгмийн эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг монгол, англи хэлээр боловсруулж, ГХЯ-ны Олон улсын гэрээ эрх зүйн газраар хянуулж, санамж бичгийг байгуулах зөвшөөрлийг авсан. Улмаар Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд 2024 оны 2 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд БНСУ- | I.02-XII.31 | 100.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлагт айлчлал хийх үеэр Санамж бичгийг байгуулсан. | | |
| 27. | Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Эрүүлийг хамгаалах, анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг шинэчилнэ. | Шинэчлэгд-сэн хэлэлцээр | - | Хэлэлцээрийг шинэчлэх процесс Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу хийгдсэн байна. | Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Оросын Холбооны Улсын Эрүүлийг хамгаалахын сайд М.А.Мурашкогийн урилгаар тус улсын Бүгд Найрамдах Буриад Улсын нийслэл Улаан-Үд хотноо 2024 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд ажлын айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Сайд С.Чинзориг, ОХУ-ын сайд М.А.Мурашко нарын уулзалтын үеэр Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэн батлах талаар санал дэвшүүлсэн боловч айлын талаас дээрх хэлэлцээрийг шинэчлэх шаардлагагүй, түүнчлэн уг асуудлыг ОХУ-ын ГХЯ шийдэх тул боломжгүй хэмээн мэдэгдсэн. энэ тухай ярианы тэмдэглэлийн 6 дугаар хуудаст тодорхой тэмдэглэгдсэн байгаа. | I.02-XII.31 | Үнэлэх болом жгүй |
| 28. | Яамны болон харьяа байгууллагуудын албан хаагчдын 2023 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлан гаргана. | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөх ёстой төрийн албан хаагчдын мэдүүлэг гаргасан хувь | Хуульд заасан хугацаанд холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хянаж хүлээн авдаг. | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөх ёстой төрийн албан хаагчид 100 хувь хуулийн хугацаанд мэдүүлэг гаргасан байна. | Нийт 780 албан тушаалтны ХАСХОМ-ыг системд баталгаажуулж, хугацаанд нь илгээсэн.<br>-Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагын ХАСХОМ мэдүүлэх албан тушаалын жагсаалтыг Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтийн албан тушаалтны жагсаалттай нийцүүлэн ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй албан тушаалтны нэрсийг боловсруулан Авлигатай тэмцэх газрын холбогдох | I.02-XII.31 | 100.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | комиссарын цахим хаягт 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн.<br>- Эрүүл мэндийн яам болон харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэгтэй нийт 622 албан тушаалтан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор meduuleg.iaac.mn хуудсанд ХАСХОМ бүрэн мэдүүлсэн. Энэ хугацаанд албан хаагчдад арга зүйн дэмжлэг үзүүлэн хугацаанд нь баталгаажуулахад дэмжлэг үзүүлж Авлигатай тэмцэх газартай хамтран цахим сургалт зохион байгуулж ажилласан. | | |
| 29. | Эрх зүйн маргаанд Эрүүл мэндийн яамыг төлөөлж оролцоно. | Шүүхээр бүрэн шийдвэрлүүлсэн эрх зүйн маргааны тоо | Эрүүл мэндийн яамтай холбоотой эрх зүйн маргаанд яамыг төлөөлж оролцдог. | Эрүүл мэндийн яамтай холбоотой эрх зүйн маргааныг хуулийн дагуу шийдвэрлүүлсэн байна. | 2024 онд нийт 22 шүүхийн маргаан байгаагаас 10 эрх зүйн маргаан эцэслэгдэн шийдвэрлэгдсэн. | I.02-XII.31 | 100.0 |
| 30. | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Байгууллагын дотоод хаягжилтыг Монгол бичгээр хийсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | - Монгол бичгийг албан хэрэг хөтлөлтөд үе шаттай нэвтрүүлэх хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ТЗУГ-ын даргаар батлуулсан.<br>- Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" стандарт /MNS 6395: 2022/-ын дагуу | I.02-XII.31 | 30.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрүүл мэндийн сайдын А4, А5 болон Эрүүл мэндийн яамны А4, А5 хэвлэмэл хуудсыг Монгол бичигт хөрвүүлж албан хэрэгцээнд нэвтрүүлэхээр эхийг Архивын ерөнхий газраар хянан баталгаажуулсан. Дээрх хэвлэмэл хуудсуудыг уйгаржин монгол бичгээр хэвлүүлэн албан хэрэгцээнд нэвтрүүлэхээр бэлэн болсон. Байгууллагын гадна хаягжилтыг Монгол бичигт хөрвүүлэхээр /Dinosaur Sign/ хаяг, реклам чимэглэлийн байгууллагаас эх бэлтгэл болон үнийн санал авсан бөгөөд гадна засварын дараа хаяг байршуулахаар хүлээж байна.<br>- Эрүүл мэндийн яамны дотор хаягжилтийг крилл болон Монгол бичгээр хийж хэвшсэн. Мөн албан хаагчдын нэрийг хуудсыг Монгол бичгээр 1 талд нь хийж хэвшсэн. | | |
| 31. | Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудын стратеги төлөвлөгөөг батлуулна. | Батлагдсан төлөвлөгөө | 2023 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн яамны харьяа 7 байгууллага стратеги төлөвлөгөөтэй байна. | Эрүүл мэндийн яамны харьяа 7 байгууллагын стратеги төлөвлөгөөг батлуулсан байна. | Эрүүл мэндийн яамны харьяа 6 байгууллага (ЗГХА-ЭЭХХЗГ, ГССҮТ, ЗӨСҮТ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС)-ын стратеги төлөвлөгөөг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хянаж засварлан Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. УХТЭ-ийн стратеги төлөвлөгөө хянагдаж байгаа бөгөөд 12 сард багтаан батлуулна. | I.02-XII.31 | 100.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дуусссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32. | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулна. | Үйл ажиллагааны тайлан | - | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024" эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, зөвлөгөөнд 160 удирдах ажилтан оролцсон. | I.02-XII.31 | 100.0 |
| 33. | Яамны хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг шинэчлэн боловсруулна. | Шинээр боловсруул-сан гэрээний дагуу байгуулсан гэрээний тоо | - | Эрүүл мэндийн яамны төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг шинэчилсэн байна. | Хөдөлмөрийн гэрээ болон Хөлсөөр ажиллах гэрээний ерөнхий загварыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн шинэчилсэн.<br>Хөдөлмөрийн гэрээг төрийн үйлчилгээний 10 ажилтантай, Хөлсөөр ажиллах гэрээг 12 ажилтантай нийт 22 албан хаагчтай тус тус шинэчлэн байгуулсан. | I.02-XII.31 | 100.0 |
| 34. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 2013-2019 оны тушаалын цахим сан үүсгэнэ. | Цахим санд орсон хадгаламжийн нэгж | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 2020-2022 оны тушаалын 101 боть хадгаламжийн нэгжээр цахим санг үүсгэсэн. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 2013-2019 оны тушаалын 159 хадгаламжийн нэгжээр цахим санг үүсгэсэн байна. | Сайд, төрийн нарийн бичгийн даргын 2013-2019 оны тушаалууд 159 хадгаламжийн нэгжийн Сайдын 3480 тушаал, ТНБД-ын 1935 нийт 5415 тушаалын 33069 хуудсыг сканердаж цахим хэлбэрт оруулсан. | I.02-XII.31 | 100.0 |
| 35. | Яамны интернэт сүлжээний зохион байгуулалтыг судалж, шаардлагатай физик холболт болон хаягжилтыг хийнэ. | Судалгааны тайлан Шинэчлэгдсэн физик холболтын тоо | - | Яамны интернэт сүлжээ судалгааг хийсэн байна.<br>Судалгааны үр дүнд үндэслэн | - Яамны интернэт сүлжээнд ашиглагдаж байгаа сүлжээний зохион байгуулалтын судалгаа хийж тайлан боловсруулсан.<br>- Яамны сервер болон сүлжээний зохион байгуулалтыг хийж, | I.02-XII.31 | 100.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | физик холболт хийж хаягжуулсан байна. | шаардлагатай 34 интернэт сүлжээний, 14 харилцаа холбооны нийт 48 удаагийн физик холболт хийж, хаягжуулсан. | | |
| 36. | Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага болон төсөл хөтөлбөрүүдийн нэгжүүдэд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр шалгалт хийж, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллана. | Шалгалт хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | - | Архив, албан хэрэг хөтлөлтийн шалгалтыг 23 байгууллагад хийж, зөвлөмж хүргүүлсэн байна. | Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу харьяа 17 эрүүл мэндийн байгууллагад 11 үзүүлэлтээр архив, албан хэрэг хөтлөлтийн шалгалтыг 03 сарын 11-ээс 04 дүгээр сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн. | I.02-XII.31 | 100.0 |
| 37. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулна. | Батлагдсан тушаал | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/618 дугаар тушаалаар батласан. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, ажиллах журмыг батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж холбогдох газар хэлтсээс саналыг авч тусгасан бөгөөд Эрүүл мэндийн яамны бүтцийн өөрчлөлтийн дараа албажуулахаар ажиллаж байна. | I.02-XII.31 | 90.0 |
| 38. | Яамны төрийн нууцтай холбоотой үйл ажиллагааг хууль журмын хүрээнд зохион байгуулна. | Нууцын үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн тоо | 2023 онд нууцын үйл ажиллагаатай холбоотой зөрчил гараагүй. Ирсэн нууц, маш нууц албан бичиг | Нууцтай холбоотой үйл ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан байна. | Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны 2023 онд хийсэн ажлын тайланг Тагнуулын Ерөнхий газарт нууцын журмаар албан бичгээр хүргүүлсэн. Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, | I.02-XII.31 | 100.0 |



52

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаандаа шийдвэрлэгдэж, хэрэгжилт 100 хувь байсан. | | бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэж өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ирсэн нууц, маш нууц албан бичгүүдийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж ажилласан ба 100 % шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн. | | |
| 39. | Олон улсын конвенцийн хэрэгжилтийн тайланг хянаж хүргүүлнэ. | Хянаж хүргүүлсэн конвенцийн хэрэгжилтийн тайлан | - | Монгол Улсын нэгдэн орсон эрүүл мэндийн салбарын чиг үүрэгт хамаарах олон улсын конвенцийн хэрэгжилтийн тайланг хянаж хүргүүлсэн байна. | Мансууруулах эмийн тухай конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенци, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенциудын хэрэгжилтийн хувьд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар нь улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудаас тухайн улирлын эмийн зарцуулалтын тайланг авч, холбогдох олон улсын байгууллагаас тогтоосон тусгай аргачлалын дагуу нийт эмийн хэрэглээг тооцож, цэвэр тоог тогтоон тайланг улирал болон жилээр Австри Улсын Вена хот дахь Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөлд хүргүүлдэг. 2024 оны улирал тутмын тайланг ЭТҮГ-аас тогтоосон хугацаанд нь хүргүүлсэн. Бусад 3 конвенцийн тайланг 2 жил тутамд явуулдаг. Дээрх 3 конвенцийг хэрэгжилтийг гаргуулахаар НЭМБГ, ЭТБГ-т дотоод меморандумыг хүргүүлээд байна. | I.02-XII.31 | 30.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 40. | Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна. | Батлагдсан тушаал | 2018 оны тушаалаар зохицуулагдаж байгаа. | Тэргүүлэх чиглэл шинэчлэгдэн батлагдсан байна. | Монгол Улсын хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан 2024-2027 онд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хязгаарлах, олгохгүй чиглэлийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, Эрүүл мэндийн яамны газрын дарга нараар тойруулж зуруулан батлуулахад бэлэн болсон. | I.02-XII.31 | 90.0 |
| 41. | Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам болон шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. | Шинэчлэн батлагдсан журам | Эрүүл мэндийн сайдын 2017 оны A/503, 2019 оны A/554, 2020 оны A/179, A/180-р тушаалыг мөрдөж байна. | Магадлан итгэмжлэлийн журам болон шалгуур үзүүлэлт шинэчлэгдэн батлагдсан байна. | - Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам болон шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, ажлын хэсгийн хурлаар 3 удаа хэлэлцүүлсэн.<br>- Магадлан итгэмжлэлийн журмын төслийг 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Эрүүл Мэндийн Сайдад, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар танилцуулж, эрх зүйн орчинг дахин судалж боловсруулахаар буцаагдсан болно.<br>- Шалгуур үзүүлэлтийн дэд бүлгүүдэд шүүлт хийж, давхардсан утгатай шалгуур үзүүлэлтүүдийг хасах, нэгтгэх, өөрчлөх үйл ажиллагаа хийгдсэн.<br>- Олон улсын магадлан итгэмжлэлийн стандарттай харьцуулан шалгуур | I.02-XII.31 | 30.0 |



65

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэлтийн шинэчлэлийг хийх ажил үргэлжилж байна. | | |
| 42. | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. | Батлагдсан тушаал | Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл, тушаалын төслийн нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг боловсруулсан | Шалгуур үзүүлэлт шинэчлэгдэн батлагдсан байна. | - Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлж байгаатай холбоотой "Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авахад мөрдөх шалгуур үзүүлэлтийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2/3928 дугаар албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт шилжүүлэв.<br>- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх ажлын байранд үнэлгээ хийх хяналтын хуудас (нийтлэг шаардлага болон өвөрмөц | I.02-XII.31 | 30.0 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагаар), ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудас, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, батлуулахад бэлэн болсон. | | |
| Нэмэлтээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | | | | | | | |
| 43. | Засгийн газрын цом тэмцээнийг зохион байгуулна. | Тэмцээн зохион байгуулагдсан байна. | /-/ | Засгийн газрын цом тэмцээнийг зохион байгуулсан байна. | Төрийн захиргааны төв байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон зохион байгуулдаг "Засгийн газрын цом-2024" спортын таван төрөлт тэмцээнийг Эрүүл мэндийн яам 2024 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 16 яам, ЗГХЭГ, Хяналт, үнэлгээний үндэсний хорооний нийт 1000 гаруй төрийн албан хаагчид оюун ухаан, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс нийлбэр дүнгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын баг тамирчид тэргүүлж, энэ жилийн шилжин явах цомын эзэд боллоо. | XI.25-XII.01 | 100 |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тус тэмцээнд E-Sport төрөлд ЭМЯ-ны эрэгтэй баг мөнгөн медаль хүртлээ. | | |
| 44. | Төвлөрлийг сааруулах үндэсний багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийнэ. | Дэмжлэгт хяналт хийсэн байгууллагын тоо | - | Дэмжлэгт хяналт хийх үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | Өвөрхангай, Өмнөговь аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд ажиллах төвлөрлийг сааруулах үндэсний багийн үйл ажиллагаанд дэмжлэг хяналтад Эрүүл мэндийн сайд оролцох үйл ажиллагааг зохион байгуулсан. | I.02-XII.31 | 100 |
| 45. | Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудад тэргүүлэх чиглэлийг танилцуулах уулзалтыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны тайлан | /-/ | /-/ | Мөн "Нийгмийн эрүүл мэндийн бодлого тэргүүлэх чиглэл болох нь" уриа дор салбарын удирдах ажилтны өргөтгөсөн зөвлөгөөнийг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд УИХ, Засгийн газар, Эрүүл мэндийн яам, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн байгууллагын төлөөлөл зэрэг нийт 1000 гаруй удирдах ажилтан оролцсон. | X.15 -X.20 | 100 |
| Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, | | | | | | | |
| 46. | Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллана. | Тогтоогдсон ёс зүйн зөрчил | - | Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | Ёс зүйн зөрчилгүй ажилласан. | I.02-XII.31 | |

| № | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 47. | Албан бичиг, өргөдлийг журмын дагуу шийдвэрлэнэ. | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо | - | албан бичиг, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар ТЗУГ 1708 бичгийг хүлээн авч, 899 өргөдөл гомдлыг шийдвэрлэн, 2521 албан бичгийг боловсруулан явуулсан байна. | I.02-XII.31 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдана. | Сургалтын гэрчилгээ | Дэс түшмэлийн сургалтад хамрагдсан. | Ахлах түшмэлийн багц цагийн сургалтад хамрагдсан байна. | Ахлах түшмэлийн багц цагийн сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн. | I.02-XII.31 | 100.0 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА — Б.БАТБАЯР / ........................... / — 2024.12.10

*(Албан тушаал)* — *(Нэр, гарын үсэг)* — *(Огноо)*



69